



МОНГОЛ УЛСЫН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2025 оны 02 сарын 19 өдөр

Дугаар А/62

Улаанбаатар хот

"Хөдөө аж ахуйн бирж" ХХК-ийн
дүрэмд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дахь заалт Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 11-ны өдрийн хуралдааны 32 дугаар тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А/621 дүгээр тушаалаар баталсан "Хөдөө аж ахуйн бирж" ХХК-ийн дүрмийн 2.4-т "Хөдөө аж ахуйн биржийн албан ёсны хаяг, шуудангийн хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй, 4-р хороо, баруун сэлбэ, Хишиг төв 301, 303, 304 тоот" гэж заасныг "Хөдөө аж ахуйн биржийн албан ёсны хаяг, шуудангийн хаяг: Монгол Улс, Дархан-Уул аймгийн Дархан сум, 14 дүгээр баг, Олимпын-3, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 1 дүгээр давхар" гэж өөрчилсүгэй.

САЙД



Ж.ЭНХБАЯР

1301010147

**“ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ” ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ
КОМПАНИЙН ДҮРЭМ**

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ


- 1.1. Энэхүү дүрмээр “Хөдөө аж ахуйн бирж” хязгаарлагдмал хариуцлагатай компани (цаашид “Хөдөө аж ахуйн бирж” гэх)-ийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, зорилго, зарчим, төсөв болон хувьцаа эзэмшигч, Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын эрх, үүрэг, тэдгээрийн үйл ажиллагааны хамрах хүрээг тодорхойлох ба Хөдөө аж ахуйн биржийн нягтлан бодох бүртгэл, дотоод зэрэгтэй холбогдон үүсэх бусад харилцааг зохицуулна.
- 1.2. Хөдөө аж ахуйн бирж нь Авилгын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Иргэний хууль, Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа удирдлага болгон энэ дүрмийн хүрээнд ашгийн төлөө үйл ажиллагаа явуулна.
- 1.3. Энэхүү дүрмээр нарийвчлан зохицуулаагүй бусад харилцааг холбогдох хууль тогтоомжийн бусад актаар зохицуулна.

**ХОЁР. ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖИЙН ОНООСОН
НЭР, ХАЯГ**

- 2.1. Хөдөө аж ахуйн биржийн оноосон нэр монгол хэлээр “Хөдөө аж ахуйн бирж” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани, товчилсон нэр “Хөдөө аж ахуйн бирж” ХХК гэнэ.
- 2.2. Хөдөө аж ахуйн биржийн оноосон нэрийг англи хэлээр “Mongolian Agricultural Commodity Exchange” гэнэ.
- 2.3. Хөдөө аж ахуйн бирж нь өөрийн нэр бүхий тамга, бэлгэдэл, албан бичгийн хэвлэмэл хуудастай байх бөгөөд Хөдөө аж ахуйн биржийн тамгыг Гүйцэтгэх захирал зохих журмын дагуу эзэмшиж, хадгална.
- 2.4. Монгол Улс, Дархан-Уул аймгийн Дархан сум, 14 дүгээр баг, Олимпын-3, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 1 дүгээр давхар.
- 2.5. Утас: 70148779, цахим шуудан: info@mce.mn

**ГУРАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖИЙН ЗОРИЛГО,
ЭРХЛЭХ АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ**

- 3.1. Хөдөө аж ахуйн биржийн эрхэм зорилго нь Монгол Улсад олон улсын стандартад нийцсэн хөдөө аж ахуйн (цаашид “ХАА” гэх)-н гаралтай бараа,



түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн нэгдсэн тогтолцоог бий болгох, бараа, түүхий эдийн арилжааг тогтсон журмын дагуу зориулалтын байранд /танхимын болон цахим сүлжээгээр/ зохион байгуулах, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн үнэ цэнийг байнга нэмэгдүүлэхэд оршино.

- 3.2. Хөдөө аж ахуйн бирж нь үйл ажиллагаандаа бие даасан, ил тод, хараат бус байх, ХАА-н гаралтай, түүхий эдийн арилжааны зах зээлд оролцогчдын эрх тэгш байдлыг ханган ажиллах үндсэн зарчмыг баримтална.
- 3.3. Хөдөө аж ахуйн бирж нь бие даасан тайлан тэнцэлтэй, харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэн, үүрэг хариуцлага хүлээдэг, хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, түүнийг захиран зарцуулах эрх нь Иргэний хууль болон Компанийн тухай хууль, Хөдөө Аж Ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль болон энэхүү дүрмээр хязгаарлагддаг, хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэртэй байна.
- 3.4. Хөдөө аж ахуйн бирж нь хуульд заасан дараах үндсэн үйл ажиллагааг эрхэлнэ. Үүнд:
 - 3.4.1. Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн спот болон үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжаа эрхлэх;
 - 3.4.2 Хөдөө аж ахуйн гаралтай, түүхий эдийн арилжааг танхимын болон цахим хэлбэрээр зохион байгуулах.
 - 3.4.3 Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн нэгдсэн тогтолцоог бий болгох.
- 3.5. Хөдөө аж ахуйн бирж нь үйл ажиллагаагаа хугацаагүй явуулна.

ДӨРӨВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖИЙН ЭРХ

- 4.1. Хөдөө аж ахуйн биржийн иргэний эрх зүйн чадвар нь улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсэх ба дүрэмд заасан үйл ажиллагаагаа Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн хүрээнд, хараат бусаар бие даан явуулна.
- 4.2. Хөдөө аж ахуйн бирж нь өөрийн үйл ажиллагааны хүрээнд аливаа гадаад, дотоодын байгууллага, хувь хүмүүстэй хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллах эрхтэй.
- 4.3. Хөдөө аж ахуйн биржийн Гүйцэтгэх захирал нь үндсэн ба туслах үйл ажиллагаагаа хэвийн явуулах зорилгоор мэргэжил, ур чадвар, дадлага туршлагатай хүмүүсийг хөдөлмөрийн гэрээгээр авч ажиллуулах эрхтэй ба тэдгээрийн ажиллах нөхцөл, цалин хөлс, урамшууллын хэмжээг зохих журмын дагуу тогтооно.

ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖИЙН ҮҮРЭГ

- 5.1. Хөдөө аж ахуйн бирж нь үйл ажиллагаагаа Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн явуулах үүрэгтэй.



- 5.2. Хөдөө аж ахуйн бирж нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аудитын тухай хууль болон Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлд заасны дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөн, санхүүгийн тайлан гаргана.
- 5.3. Хөдөө аж ахуйн бирж нь Монгол Улсын татварын хууль тогтоомжийн дагуу орлого, зарлагаа тодорхойлж, албан татвараа сайн дураараа, үнэн зөв төлнө.
- 5.4. Хөдөө аж ахуйн бирж нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсдын өмнө хуулиар хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлж ажилтнуудыг зохих нийгмийн даатгалд хамруулна.
- 5.5. Хөдөө аж ахуйн бирж нь энгийн хувьцааг заавал гаргах үүрэг хүлээхээс гадна давуу эрхийн хувьцаа, опцион болон хуульд заасан бусад үнэт цаасыг гаргаж болно.
- 5.6. Хөдөө аж ахуйн бирж нь Компанийн тухай хуулийн 97 дугаар зүйлд заасан баримт бичгүүдийг хадгалах үүрэгтэй ба Хөдөө аж ахуйн биржтэй холбоотой баримт бичгийн нууцыг чанд хадгалах үүрэгтэй.
- 5.7. Хөдөө аж ахуйн бирж нь үүсгэн байгуулах баримт бичигт болон улсын бүртгэлийн жагсаалтад агуулагдаж байгаа бусад мэдээлэлд оруулсан өөрчлөлтүүдээ хуульд заасан хугацаанд бүртгэх байгууллагад бүртгүүлнэ.

ЗУРГАА. ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖИЙН ХАРИУЦЛАГА, ХОРИГЛОХ ЗҮЙЛ

- 6.1. Компанийн тухай хуулийн 9.1-д заасны дагуу Хөдөө аж ахуйн бирж нь өөрийн бүх эд хөрөнгөөр хариуцлага хүлээнэ.
- 6.2. Хөдөө аж ахуйн бирж нь хувьцаа эзэмшигчийн бусад этгээдийн өмнө хүлээх үүргийг хариуцахгүй.
- 6.3. Хөдөө аж ахуйн биржийн эрх бүхий албан тушаалтан нь Компанийн тухай хуулийн 84, 85 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээнэ.
- 6.4. Хөдөө аж ахуйн бирж, хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан болон Хөдөө аж ахуйн биржийн ажилтнуудад дараах зүйлийг хориглоно.
- 6.4.1. Хуулиар хориглосон арга хэрэгслийг ашиглаж, шударга бусаар давуу байдал бий болгоход чиглэсэн үйл ажиллагаа явуулах;
- 6.4.2. Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагааны талаар буруу ташаа, худал мэдээллийг олон нийтэд тараах;
- 6.4.3. Холбогдох хууль тогтоомж болон Хөдөө аж ахуйн биржийн дотоод журмаар тогтоосон Хөдөө аж ахуйн биржийн нууц мэдээллийг задруулах;
- 6.4.4. Хуульд хориглохоор заасан бусад үйл ажиллагаа

ДОЛОО. ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ БОЛОН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ

- 7.1. Хөдөө аж ахуйн биржийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг Компанийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, өөрийн хөрөнгийн хэмжээг Компанийн тухай хуулийн мөн зүйлийн 30.2-т заасны дагуу тодорхойлно.





- 9.2. Хөдөө аж ахуйн биржийн хувьцаа эзэмшигч өөрийн эзэмшлийн хувьцаагаа хэсэгчлэн эсхүл бүхэлд нь гуравдагч этгээдэд худалдах буюу шилжүүлэх асуудлыг хувьцаа эзэмшигчдийн гэрээгээр зохицуулна.
- 9.3. Хувьцаа эзэмшигч нь хувьцаагаа гуравдагч этгээдэд худалдах, шилжүүлэх тохиолдолд Компанийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан журмын дагуу Хөдөө аж ахуйн бирж болон бусад хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэж бусад хувьцаа эзэмшигчийн тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах эрхийг хэрэгжүүлэх боломжоор хангана.

АРАВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

- 10.1 Компанийн хувьцаа эзэмшигчийн хурлын бүрэн эрхийг Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.
- 10.2 Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн зайлшгүй шаардлагатай гэж үзсэн бол тодорхой асуудлаар шийдвэр гаргах эрхийг Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагыг төлөөлөх эрх бүхий этгээдэд шилжүүлж болно.
- 10.3 Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлд зааснаас гадна Төлөөлөн удирдах зөвлөлийн хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудлыг холбогдох журмын дагуу шийдвэрлэнэ.
- 10.4 Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага хувьцаа эзэмшигчийн хувьд компанийн хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэн бие даасан, үр ашигтай үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлж, компанийн хөрөнгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого, шийдвэрээр тогтвортой дэмжиж ажиллана.
- 10.5 Хувьцаа эзэмшигч нь хууль тогтоомж болон энэ дүрмээр бүрэн эрхэд нь хамааруулснаас бусад асуудлаар компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд оролцохгүй.
- 10.6 Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн шийдвэрээр компанийн хуримтлагдсан ашгийг зарцуулна.

АРВАН НЭГ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

- 11.1 Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт Хөдөө аж ахуйн биржийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид "ТУЗ" гэх/ байна. ТУЗ-ийн үйл ажиллагаагаа явуулах хэлбэр нь ТУЗ-ийн хурал байна.
- 11.2 ТУЗ нь 9 гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 3 нь хараат бус гишүүн байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь санхүү эдийн засаг, хууль, компанийн засаглалын чиглэлээр мэргэшсэн байх бөгөөд хараат бус гишүүд нь салбар, мэргэжлийн холбоод болон төрийн бус байгууллагын гишүүд байна.
- 11.3 ТУЗ нь Компанийн тухай хуулийн 82 дугаар зүйлд зааснаар ТУЗ-ийн нарийн бичгийн даргатай байна.



- 11.4 ТУЗ-ийн даргыг ТУЗ-ийн хуралд оролцсон гишүүдийн ердийн олонхийн саналаар сонгоно.
- 11.5 ТУЗ нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлд зааснаас гадна дараах бүрэн эрхтэй байна.
- 11.5.1 Компанийн стратегийн зорилтуудыг тодорхойлж, дунд болон урт хугацааны бизнес төлөвлөгөөг батлах;
- 11.5.2 Хөдөө аж ахуйн биржийн Гүйцэтгэх захирлыг хуульд заасан журмын дагуу томилох, чөлөөлөх түүний бүрэн эрхийг тогтоох;
- 11.5.3 Хөдөө аж ахуйн биржийн Гүйцэтгэх захиралтай байгуулах байгуулах гэрээний нөхцөл, түүнд олгох, цалин, шагнал урамшуулал, өмч хөрөнгийг захиран зарцуулах эрх, хариуцлагын хэмжээг тогтоох гэрээ байгуулах;
- 11.5.4 Хөдөө аж ахуйн биржийн санхүүгийн болон жилийн үйл ажиллагааны тайлангийн талаар дүгнэлт гаргах;
- 11.5.5 Компанийн тухай хуулийн 6 дугаар бүлэгт заасан журмын дагуу ногдол ашгийн хэмжээ, түүнийг төлөх журмыг тодорхойлж, хуваарилах;
- 11.5.6 ТУЗ-ийн дэргэдэх тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороог байгуулах, цалин урамшуулал, бусад зардлыг тогтоох;
- 11.5.7 Хөдөө аж ахуйн биржийн арилжааны болон төлбөр тооцооны шимтгэлийн хувь хэмжээ болон холбогдох бусад хураамжийн хэмжээг Биржийн эдийн засаг, санхүүгийн байдал, гүйцэтгэх удирдлагын багаас санал болгосон тооцоо судалгаанд нийцүүлэн тогтоох, өөрчлөх;
- 11.5.8 Хөдөө аж ахуйн биржийн зохион байгуулалтын бүтэц, орон тоог батлах;
- 11.5.9 Компанийн төсөв, үйл ажиллагааны болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлах;
- 11.5.10 Гүйцэтгэх захирлын үйл ажиллагааны журам, компанийн засаглалын зарчим болон Гүйцэтгэх захирлаас танилцуулсан компанийн үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журмыг хэлэлцэх, батлах;
- 11.5.11 Компанийн тайлан тэнцэлд хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг хэлэлцэж шийдвэр гаргах;
- 11.5.12 Их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий гэрээ хэлцлийн үнэ болон уг гэрээг байгуулах эсэх талаар шийдвэр гаргах;
- 11.5.13 Компанийн охин компани, салбар, төлөөлөгчийн газар байгуулах шийдвэр гаргах, түүний дүрэм эсхүл үйл ажиллагааны журмыг батлах;
- 11.5.14 Энэхүү дүрэм болон Компанийн тухай хуульд заасны дагуу зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэхээс бусад бүх асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх.
- 11.5.15 Малчид, бэлтгэн нийлүүлэгчдийг дэмжихтэй холбоотой асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх;
- 11.5.16 Компанийн тухай хуулиар ТУЗ-д олгосон бусад бүрэн эрх;



- 11.6 ТУЗ-ийн хурлаар тухайн асуудлыг хэлэлцэж гаргасан хүчин төгөлдөр шийдвэргүйгээр ТУЗ-ийн гишүүн нь ТУЗ-ийн тусгайлсан зөвшөөрөлгүйгээр ТУЗ-ийн байр суурийг илэрхийлэхийг хориглоно.
- 11.7 ХАА-н гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль, энэхүү дүрмээр болон хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрхээр тогтоогоогүй ТУЗ, түүний үйл ажиллагаатай холбоотой аливаа асуудлыг Компанийн тухай хуульд заасан бүрэн эрхийн дагуу ТУЗ шийдвэрлэнэ.
- 11.8 ТУЗ-ийн төрийг төлөөлөх гишүүнээр томилогдсон этгээд нь төрийн мэдлийн хувьцаа эзэмшигчээс баталсан удирдамж, зааврыг баримтлан ажиллана.
- 11.9 ТУЗ нь шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороог байгуулж болох бөгөөд өөрийн үйл ажиллагааг үр өгөөжтэй, байнгын, мэргэшсэн байдлаар үйл ажиллагааг явуулах зорилготой Аудитын, Цалин урамшууллын, Нэр дэвшүүлэх хороог заавал байгуулан ажиллана.
- 11.10 ТУЗ-ийн дэргэдэх хороод нь ТУЗ-ийн гишүүдээс бүрдэх бөгөөд түүний 2/3 нь хараат бус гишүүн байна. Хороод нь Компанийн тухай хуульд заасан тодорхой чиг үүрэгтэй ажиллаж, тухайн асуудлаар дүгнэлт гаргаж, ТУЗ-ийн хуралд танилцуулан шийдвэр гаргуулах үүрэгтэй.
- 11.11 Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтвортой байдлыг хангах үүднээс Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэхдээ тухайн жилд нийт гишүүдийн 50 хувиас илүү гишүүдийг чөлөөлөхгүй
- 11.12 ТУЗ-ийн дарга компанийг төлөөлөн санхүүгийн гүйлгээ хийх, компанийн нэрийн өмнөөс гэрээ байгуулахыг хориглоно.

АРВАН ХОЁР. ТУЗ-ИЙН ХУРАЛДААН,

ШИЙДВЭР ГАРГАХ ЖУРАМ

- 12.1 ТУЗ-ийн ээлжит хурлыг сард нэг удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай гэж үзвэл ээлжит бус хуралдаан хийж болно.
- 12.2 ТУЗ-ийн дарга эсхүл ТУЗ-ийн 3 ба түүнээс дээш тооны гишүүн ТУЗ-ийн хурал хуралдуулах хүсэлтээ ТУЗ-д гаргаж, хурлаар хэлэлцэх асуудлын талаарх саналаа ирүүлсэн тохиолдолд хурлыг ТУЗ-ийн дарга зарлан хуралдуулна. Энэ зүйлд заасан журмаар хүсэлт гаргаснаас хойш ажлын 10 хоногийн дотор ТУЗ-ийн дарга хурлыг зарлан хуралдуулаагүй бол хүсэлт гаргасан гишүүд энэ дүрэмд заасан журмын дагуу хурлыг зарлан хуралдуулах эрхтэй.
- 12.3 ТУЗ-ийн хурлын зарыг захидал, факс, гишүүний Хөдөө аж ахуйн биржид бүртгүүлсэн цахим хаягийн аль нэгээр хурал хуралдахаас 2 хоногоос доошгүй хоногийн өмнө гишүүн бүрт хүргүүлнэ. Хурлын зард хурал хуралдах огноо, цаг, газрыг заахаас гадна тухайн хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт болон түүнтэй холбоотой баримт бичиг, материал, танилцуулга зэргийг хавсаргана.
- 12.4 Хурлын зар хүлээн авсан ТУЗ-ийн гишүүн нь хэлэлцэх асуудлын жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулах саналыг хурлаас өмнө ТУЗ-ийн



даргад танилцуулж болно. Уг саналыг хэлэлцүүлэх асуудлын жагсаалтад оруулах эсэхийг ТУЗ-ийн дарга шийдвэрлэнэ.

- 12.5 ТУЗ-ийн хурал нь нийт гишүүдийн дийлэнх олонхи гишүүд оролцсоноор хүчин төгөлдөр болно.
- 12.6 ТУЗ-ийн аль нэг гишүүн хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралд биечлэн оролцох боломжгүй тохиолдолд хурлаар хэлэлцэх асуудлын талаар бичгээр санал ирүүлж болох бөгөөд энэ тохиолдолд ТУЗ-ийн гишүүнийг хуралд биечлэн оролцсонд тооцно. ТУЗ-ийн гишүүн нэг жилд 2-оос илүүгүй удаа бичгээр санал өгнө.
- 12.7 ТУЗ-ийн хурлын шийдвэр нь хуралд оролцож байгаа гишүүдийн олонхийн саналаар хүчин төгөлдөр болно. Гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд ТУЗ-ийн даргын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.
- 12.8 ТУЗ шийдвэрээ тогтоол хэлбэрээр гаргана. Уг тогтоолд ТУЗ-ын дарга гарын үсэг зурж баталгаажуулна.
- 12.9 Хурлын үйл явцыг видео бичлэг эсхүл дуу хураагуураар бичиж баталгаажуулна. Хурал болсноос хойш ажлын 5 өдрийн дотор хуралдааны нарийн бичгийн дарга хуралдааны тэмдэглэлийг Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.11-т заасан журмын дагуу гаргах ба хуралд оролцсон гишүүд тэмдэглэлд гарын үсэг зурна. Хурлын тэмдэглэлийн талаар гишүүд өөр саналтай бол энэ талаар санал гаргах эрхтэй ба тэдгээр саналыг хурлын тэмдэглэлд хавсаргана.
- 12.10 ТУЗ-ийн бүх гишүүд зөвшөөрсөн тохиолдолд ТУЗ-ийн хурал хуралдахгүйгээр эчнээ санал хураалт болон бусад хэлбэрээр ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарах асуудлыг шийдвэрлэж болно.
- 12.11 ТУЗ-ийн хурлыг зарлах, хуралдуулах, хурал хүчинтэй байх, гишүүдийн хуралд оролцох, асуудлыг хэлэлцэх, хурлын дэгийг тогтоох, ТУЗ-ийн даргын эрх болон бусад холбогдох асуудлыг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулна. Энэхүү журмыг Төлөөлөн удирдах зөвлөл батална.

АРВАН ГУРАВ. ТУЗ ДЭХ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ

- 13.1 ТУЗ-ийн гишүүн нь ТУЗ-ийн хурлаар хэлэлцэгдэж буй аливаа асуудлын талаар шууд болон шууд бусаар сонирхлын зөрчилтэй байгаа тохиолдолд энэ тухайгаа ТУЗ-ийн даргад асуудлыг хурлаар хэлэлцэхээс өмнө мэдэгдэх үүрэгтэй. Ийнхүү мэдэгдээгүй тохиолдолд ТУЗ-ийн аль нэг гишүүн нөгөө гишүүнийг сонирхлын зөрчилтэй гэж үзвэл энэ талаар ТУЗ-д мэдэгдэнэ.
- 13.2 Сонирхлын зөрчилтэй ТУЗ-ийн гишүүнийг тухайн асуудлыг хэлэлцүүлэхэд байлцуулах эсэхийг ТУЗ-ийн дарга шийдвэрлэх ба санал хураалтад оролцуулахгүй.
- 13.3 ТУЗ-ийн аль нэг гишүүн нь сонирхлын зөрчилтэй гэсэн үндэслэлээр санал хураалтад оролцоогүй нь тухайн хурлын ирцэд нөлөөлөхгүй.
- 13.4 Сонирхлын зөрчилтэй ТУЗ-ийн гишүүн түүнийгээ мэдэгдэхгүйгээр хуралд оролцож санал өгсөн нь хурлын дараа мэдэгдэж улмаар сонирхлын зөрчилтэй гишүүний өгсөн санал нь санал хураалтын үр дүнд нөлөөлсөн.



бол ТУЗ-ийн даргын шийдвэрээр тухайн асуудлыг шийдвэрлэсэн ТУЗ-ийн тогтоолыг хүчингүйд тооцуулж дахин санал хураалт явуулна.

АРВАН ДӨРӨВ. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

- 14.1 Хөдөө аж ахуйн биржийн гүйцэтгэх удирдлага нь Гүйцэтгэх захирал байх бөгөөд Хөдөө аж ахуйн биржийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.
- 14.2 Гүйцэтгэх захирлын бүрэн эрхийг энэ дүрмийн холбогдох заалт болон ТУЗ-тэй байгуулсан гэрээгээр тодорхойлно.
- 14.3 Гүйцэтгэх захирал нь Хөдөө аж ахуйн биржийн дэд захирал, салбар, төлөөлөгчийн газрын захирлыг томилж, чөлөөлөхөд ТУЗ-тэй зөвшилцөнө.
- 14.4 Гүйцэтгэх захирал дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ:
 - 14.4.1 ТУЗ-ийн өмнө Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагааг бүрэн хариуцаж, ажлын үр дүнгийн биелэлтийг тайлагнан дүгнүүлэх;
 - 14.4.2 Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан биржийн нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэх;
 - 14.4.3 Хөдөө аж ахуйн биржийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдах бүрэн эрхийн хүрээнд тушаал, шийдвэр гаргах;
 - 14.4.4 Хөдөө аж ахуйн биржийг төлөөлөн үйл ажиллагаа явуулах, гэрээ хэлцэл байгуулах;
 - 14.4.5 ТУЗ-өөс баталсан бүтэц, орон тооны хязгаарын хүрээнд Хөдөө аж ахуйн биржид шаардлагатай албан тушаалын жагсаалтыг батлах, шинэчлэх, нэгжид ажиллах ажилтнуудын тоог тогтоох;
 - 14.4.6 Хөдөө аж ахуйн биржийн бүтэц, үйл ажиллагааны хэрэгцээ шаардлагад нийцүүлэн ажилтан сонгох, томилох, ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулах, сэлгэн ажиллуулах, тэдэнд нөхөн төлбөр олгох, сахилгын арга хэмжээ авах, хөдөлмөрийн гэрээг цуцлах, дуусгавар болгох;
 - 14.4.7 Хөдөө аж ахуйн биржийн үйлд ажиллагаанд зайлшгүй шаардлагатай аливаа материал хангалт, тоног төхөөрөмж, ус, байр, тээвэр үйлчилгээ зэргийг худалдан авах, ийнхүү худалдан авахтай холбогдсон шаардлагатай баталгаа, батлан даалтыг олж авах;
 - 14.4.8 Үйл ажиллагаа явуулахад шаардагдах бүх зөвшөөрөл, лицензийг холбогдох байгуулагаас авах хугацааг нь сунгуулах, хууль дүрмийг ноцтой зөрчсөн сэжиг бүхий асуудлыг ТУЗ-д яаралтай мэдэгдэх, Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагааны талаар тайлан бэлтгэх, ТУЗ-д танилцуулах;
 - 14.4.9 Төрийн байгууллага, хууль хяналтын байгууллагад Хөдөө аж ахуйн биржийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх;
 - 14.4.10 ТУЗ-өөс тодорхойлсны дагуу Хөдөө аж ахуйн биржийг ашгийн төлөө даатгалд хамруулах;



- 14.4.11 Холбогдох хууль тогтоомж, журамд заасны дагуу нягтлан бодох бүртгэл хөтлүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцах;
- 14.4.12 Хөдөө аж ахуйн биржийн банкин дахь ам.доллар болон төгрөгийн данстай холбоотой бичиг баримтад гарын үсэг зурах;
- 14.4.13 Хөдөө аж ахуйн биржийн болон өөрийн албан үүргийг гүйцэтгэх явцдаа олж авсан нууц мэдээллийг хадгалах;
- 14.4.14 Сонирхлын зөрчил бүхий хэлцлийг мэдсэн даруйдаа ТУЗ-д мэдэгдэх;
- 14.4.15 Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуульд заасан болон хөдөө аж ахуйн биржийн дотоод үйл ажиллагааны дүрэм, журам, заавар, аргачлал, хүний нөөцийн бодлого, ажил үүргийн хуваарь баталж мөрдүүлэх;
- 14.4.16 Компанийн бизнес төлөвлөгөө, жилийн төсөв болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг боловсруулж, ТУЗ-д танилцуулан, шийдвэрлүүлэх, түүнийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
- 14.4.17 Энэхүү дүрэм болон холбогдох хууль тогтоомж, хувьцаа эзэмшигчдийн болон ТУЗ-ийн тогтоол, шийдвэр, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах;
- 14.4.18 Компанийн шинээр авах худалдан авах, худалдах болон шилжүүлэн авах, акталж устгах үндсэн хөрөнгийн асуудлыг ТУЗ-д танилцуулж, чиглэл авах;
- 14.4.19 ТУЗ-ийн даргатай байгуулсан гэрээгээр олгогдсон бусад эрх үүрэг;

АРВАН ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖИЙН

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН

- 15.1. Доор дурдсан этгээд нь Хөдөө аж ахуйн биржийн эрх бүхий албан тушаалтанд тооцогдоно:
- 15.1.1. ТУЗ-ийн дарга, гишүүн, нарийн бичгийн дарга;
- 15.1.2. Гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, гүйцэтгэх захирал, дэд захирал;
- 15.1.3. Нэгжийн дарга, менежер;
- 15.1.4. Ерөнхий нягтлан бодогч.
- 15.2. Хөдөө аж ахуйн биржийн эрх бүхий албан тушаалтан нь энэхүү дүрэм, ТУЗ-ийн баталсан дотоод дүрэм, журмыг үйлд ажиллагаандаа мөрдлөг болгон, Хөдөө аж ахуйн биржийн ашиг сонирхлын төлөө үнэнч шударгаар ажиллана.
- 15.3. Энэ дүрмийн 15.1-т заасан этгээд Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.1.1-89.1.4-т заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг хийхдээ



Компанийн тухай хуульд заасан сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журмыг баримтална.

АРВАН ЗУРГАА. ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖИЙН

ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

- 16.1. Хөдөө аж ахуйн биржийн хяналтын тогтолцоо нь дараах бүтэцтэй байна:
 - 16.1.1 Зохицуулах зөвлөлийн хяналт,
 - 16.1.2. Дотоод хяналт,
 - 16.1.3 Хөндлөнгийн аудит,
- 16.2. Зохицуулах зөвлөл, түүний ажлын алба нь Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсэгт заасан чиг үүргийн хүрээнд хяналтыг хэрэгжүүлнэ.
- 16.3. Хөдөө аж ахуйн биржийн дотоод хяналтыг Гүйцэтгэх захирлын томилсон дотоод хянан шалгагч хэрэгжүүлнэ. Дотоод хяналтын журмыг Гүйцэтгэх захирал батална.
- 16.4. Дотоод хянан шалгагч Хөдөө аж ахуйн биржийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд болон холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, Хөдөө аж ахуйн биржийн эрх бүхий этгээдийн шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргана.
- 16.5. Дотоод хянан шалгагч шалгалтаар илэрсэн алдаа, зөрчил, дутагдлыг арилгах, Хөдөө аж ахуйн биржийн хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэгдсэн зөвлөмжийг гүйцэтгэх захиралд өгөх, ТУЗ-д танилцуулах, мэдээлэх үүрэгтэй
- 16.6. Хөдөө аж ахуйн биржийн жилийн санхүүгийн бүртгэл тайланд хараат бус хөндлөнгийн аудитороор хяналт шалгалт хийлгэх бөгөөд аудитын тайланг Хувьцаа эзэмшигч, Монгол Улсын эрх бүхий байгууллага болон Хувьцаа эзэмшигчээс томилсон этгээдэд танилцуулна. Нэг аудитын байгууллагын ажиллах дээд хугацаа 3 жил байна.
- 16.7. Хөндлөнгийн аудитын дүгнэлтийг ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж, дүгнэлт гаргана.

АРВАН ДОЛОО. ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ

- 17.1. Жил бүрийн дөрөвдүгээр улиралд ТУЗ-өөс Хөдөө аж ахуйн биржийн ирэх оны бизнес төлөвлөгөөг батлах (цаашид “Бизнес төлөвлөгөө” гэх) бөгөөд уг төлөвлөгөөнд тухайн жилд худалдан авах их хэмжээний хэлцлийн жагсаалтыг тусгасан байна.
- 17.2. Бизнес төлөвлөгөөнд заасан их хэмжээний хэлцлийн жагсаалтыг ТУЗ-ийн гишүүд санал нэгтгэйгээр батална.



- 17.3. Бизнес төлөвлөгөөнд заасан их хэмжээний хэлцлийн жагсаалтын хүрээнд хийгдсэн хэлцлийг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу хийгдсэн хэлцэл гэж үзэх ба харин уг төлөвлөгөөнд тусгагдаагүй Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн дагуу их хэмжээний хэлцэлд тооцогдох бусад хэлцэл хийхэд Компанийн тухай хуулийн 88 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

**АРВАН НАЙМ. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ,
ТАТВАР САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

- 18.1. Хөдөө аж ахуйн биржийн санхүүгийн жил нь жил бүрийн 1 дүгээр сарын 1-нээс эхэлж 12 дугаар сарын 31-нд дуусна.
- 18.2. Санхүүгийн болон нягтлан бодох бүртгэл тооцоо нь Монгол Улсын Холбогдох хууль тогтоомж болон нягтлан бодох бүртгэлийн олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн стандартын дагуу хэрэгжүүлнэ.
- 18.3. Хөдөө аж ахуйн бирж Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн аливаа хураамж, газар ашигласны төлбөр зэргийг оролцуулан орлогын болон бусад төрлийн татварыг үндэсний мөнгөн тэмдэгтээр төлнө.
- 18.4. Хөдөө аж ахуйн бирж нь өөрийн ашгаас улсын төсөвт төлөх татварыг төлсний дараа Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу өөрийн санхүүгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчээс тогтоосон хэмжээгээр нөөцийн болон бусад сан байгуулж болно.
- 18.5. Хөдөө аж ахуйн бирж нь санхүүгийн үзүүлэлтээ улирал болон жилээр, орлого, зарлагын мэдээллээ холбогдох татварын болон аудитын байгууллагад тогтоосон хугацаанд гаргаж өгнө.
- 18.6. Хөдөө аж ахуйн бирж нь төгрөгийн болон чөлөөт хөрвөх гадаад мөнгөн тэмдэгтийн дансыг Монгол Улсын болон гадаадын аливаа банкинд нээлгэж болно.
- 18.7. Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ:
- 18.7.1 Хөдөө аж ахуйн биржийн хөрөнгө, ашиг, зарлагын бүртгэлийг бүрэн хөтлөх
- 18.7.2. Хөдөө аж ахуйн биржийн санхүүгийн тайлан бүртгэл тооцоог Монгол Улсын нягтлан бодох, санхүү, бүртгэлийн тухай холбогдох хууль тогтоомж, олон улсын стандартад нийцүүлэн хуульд заасан журмын дагуу хийх
- 18.7.3. Батлагдсан төсвийн хэмжээнд Хөдөө аж ахуйн биржийн зарлагын хэмжээг зохицуулах



18.7.4. Гүйцэтгэх захирал болон ТУЗ-ийн өмнө санхүүгийн бүх хэлцэл болон Хөдөө аж ахуйн биржийн санхүүгийн байдлын талаар хариуцлага хүлээх, тайлагнах.

АРВАН ЕС. ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖИЙГ ӨӨРЧЛӨН

БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ

- 19.1. Хөдөө аж ахуйн биржийг хувьцаа эзэмшигчдийн хурлын болон шүүхийн шийдвэрээр өөрчлөн байгуулах буюу татан буулгана.
- 19.2. Хөдөө аж ахуйн биржийг татан буулгасан тохиолдолд Хөдөө аж ахуйн биржийн төлөх ёстой бүх өр төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн хөрөнгийг хувьцаа эзэмшигчдэд хуваарилан шилжүүлнэ.
- 19.3. Хөдөө аж ахуйн биржийг өөрчлөн байгуулах болон татан буулгах асуудлыг Компанийн тухай хуулийн 26-29 дүгээр зүйлд заасан журмын дагуу гүйцэтгэнэ.

ХОРЬ. ХЭРЭГЛЭГДЭХ ХУУЛЬ ТОГТООМЖ

- 20.1. Энэхүү дүрмийг зөрчсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

